



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2024/36/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дундговь аймаг 2024 он	Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Ихбаяр Утас: 70593113 Цахим хаяг: ikhbayard@audit.gov.mn Аудитор: Д.Должинсүрэн Утас: 70593113 Цахим хаяг: Doljinsuren@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

..... 0

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ 2

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ 4

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан 4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан 4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан 5

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 5

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан 6

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ 6

3.1 Төлбөрийн акт 6

3.3 Зөвлөмж 6

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ 16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин
НДСОТТТ	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ


**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайншалан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2024-03-25 № 111

тантай _____ -ны № _____ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА
Г.БАТЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдсантай холбоотой 1 төрийн албан хаагч шилжин ирж, орон тоо, холбогдох бараа материал, үндсэн хөрөнгүүд нэмэгдсэн. Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн дагуу 2024 оноос Нийгмийн даатгалын газар болохтой холбоотойгоор дотор гадна хаяг, нэр солих, албан бичиг, мэдээллийг цаасаар архивлан хадгалахтай холбоотой бараа материалын зардал өссөн байна. Мөн Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2023 оны 07 сарын сарын 01-ийн өдрөөс төрийн албаны үндсэн цалин, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ нэмэгдсэн, оны эхнээс орон нутгийн нэмэгдэл олгодог болсонтой холбоотойгоор байгууллагын батлагдсан төсөв, зардлын гүйцэтгэлүүд тус тус өссөн байна. Санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний

олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилт, 62 арга хэмжээг хэрэгжүүлж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргатай байгуулсан төлөвлөгөөний үнэлгээгээр 87.6, Дундговь аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 90.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8,099,341.7	7,474,886.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,817,938.3	5,870,670.3
33	АВЛАГА	2,265,217.1	1,569,043.6
35	БАРАА МАТЕРИАЛ	16,186.3	35,172.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	477,904.6	459,637.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	477,904.6	459,637.6
39200	Биет хөрөнгө	458,313.2	441,721.6
39300	Биет бус хөрөнгө	19,591.3	17,916.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III	8,577,246.2	7,934,524.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	64,990.4	217,318.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	64,990.4	217,318.0
41300	Өглөг	3,011.8	5,183.7
41400	Урьдчилж орсон орлого	61,978.6	212,134.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,512,255.8	7,717,206.1
51	Засгийн газрын хувь оролцоо	8,512,255.8	7,717,206.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	412,290.8	412,290.8
51200	Хуримтлагдсан үр дүн	7,960,532.1	7,165,482.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	139,433.0	139,433.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,577,246.2	7,934,524.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	62,375,374.5	67,009,346.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	18,800,632.2	23,963,481.5
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	18,800,632.2	23,963,481.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	53,077.4	208,095.9
120	Нийтлэг татварын бус орлого	53,077.4	208,095.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	43,521,664.8	42,837,769.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	60,376,599.6	67,803,680.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60,376,599.6	67,803,680.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	631,036.7	1,041,358.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	453,826.3	823,980.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,300.7	102,222.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,848.6	38,920.4
2104	Хангамж, бараа материалын зардал	21,294.4	17,742.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,389.8	1,000.0
2107	Томилолт, зочны зардал	1,392.7	9,719.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,792.0	8,593.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,192.2	39,180.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,745,562.9	66,762,321.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	1,998,774.9	-794,333.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	1,998,774.9	-794,333.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,514,565.8	6,514,565.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,084.9	-1,084.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,513,480.9	6,513,480.9

Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

9	Тайлант үеийн үр дүн	1,998,774.9	1,998,774.9
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,512,255.8	8,512,255.8
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,512,255.8	8,512,255.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-716.3	-716.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,511,539.5	8,511,539.5
19	Тайлант үеийн үр дүн	-794,333.4	-794,333.4
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	7,717,206.1	7,717,206.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Мянган төгрөг/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	62,532,620.3	67,953,571.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	18,429,437.5	23,879,830.3
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	18,429,437.5	23,879,830.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	56,930.4	143,655.1
120	Нийтлэг татварын бус орлого	56,930.4	143,655.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	44,046,252.4	43,930,086.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	60,363,189.0	67,900,839.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60,363,189.0	67,900,839.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	597,022.0	1,023,557.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	453,826.3	823,980.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,300.7	102,222.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,333.4	40,435.6
2104	Хангамж, бараа материалын зардал	23,379.2	34,668.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,395.0	1,790.0
2107	Томилолт, зочны зардал	1,392.7	9,719.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,400.2	7,572.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	994.5	3,169.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,766,166.9	66,877,281.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,169,431.3	52,732.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,169,431.3	52,732.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,648,507.0	5,817,938.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,817,938.3	5,870,670.3

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөг/			
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	64,768,744.3	62,503,248.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	64,768,744.3	62,503,248.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,047,517.7	1,002,085.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	837,529.9	806,011.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,691.5	99,987.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,299.3	40,435.6
2104	Хангамж, бараа материалын зардал	38,214.7	34,668.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,405.4	1,790.0
2107	Томилолт, зочны зардал	11,462.7	9,719.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,014.2	7,572.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,900.0	1,900.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,721,226.6	61,501,163.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	63,721,226.6	61,501,163.1
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	64,768,744.3	27,895,602.2
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,739,417.4	7,739,417.4
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	57,029,326.9	20,075,297.3
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	80,887.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,817,938.3

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	5,870,670.3
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	77	71
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	38	35
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	38	35

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
П	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20,203.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	20,203.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,203.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,969.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,234.5
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	20,203.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,203.5
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,203.5

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,888.9 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 70.5 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,818.4 мянган төгрөгийн 2 зөрчилд хугацаатай зөвлөмж хүргүүлсэн байна.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар 70.5 мянган төгрөгийн 2 зөрчилд хугацаатай төлбөрийн акт хүргүүлээ.

1. Албан хаагчдад албан томилолттой үед хоолны зардлыг 52.0 мянган төгрөгөөр давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т /Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.4-т /Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно/, Сангийн сайдын 2022 оны “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай” 120 дугаар тушаалын 1-т /Төрийн албан хаагчийн албан томилолтын хоолны зардлыг суманд 24,000 төгрөг, аймгийн төвд 28,000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 32,000 төгрөгөөр, байрны зардлыг суманд 40,000 төгрөг, аймгийн төвд 90,000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 110,000 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай/ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2. Албан хаагчид төрийн албанд ажилласан жилийн нэмэгдлийг 18.5 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т /Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын 2-т / Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно/, /Төрийн алба хаасан хугацаа 12 дахь жил (133 – 144 сар) бол албан тушаалын сарын үндсэн цалингаас бодох хувь 11 хувь байна/ гэж заасныг тус тус зөрчсөн байна./

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Төсвийн жилийн дундуур 1,818.4 мянган төгрөгөөр халаалтын зардлыг нэмэгдүүлэн гэрээ байгуулж, олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.2.5.-д /төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх/, 16.5.5-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ заасныг мөн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

“Батлагдсан төсвийн дагуу зарлага гаргаж, төсвийн жилийн дундуур зарлага нэмэгдүүлэх, аливаа шийдвэр гаргахгүй байх”

2. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудаст 5 сая төгрөгөөс дээш гарсан зарим зардлыг мэдээлээгүй. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн /Шилэн дансны зарчим/ 4.1.3-т /тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх/ / заасныг мөн нийцсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

“Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандарт тогтоосон журмыг уншиж судлан хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэл байршуулах ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах”

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хуулийн хугацаанд гарган ирүүлж², хэрэгжилтийг 2024.05.25-ны өдрийн дотор ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Албан хаагчдад албан томилолттой үед хоолны зардлыг 52.0 мянган төгрөгөөр давхардуулан олгосон	1	52.0	1	52.0								
Албан хаагчид төрийн албанд ажилласан жилийн нэмэгдлийг 18.5 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон.	1	18.5	1	18.5								
Төсвийн жилийн дундуур 1,818.4 мянган төгрөгөөр халаалтын зардлыг нэмэгдүүлэн гэрээ байгуулж, олгосон.	1	1,818.4					1	1,818.4				
Нийт дүн	3	1,888.9	2	70.5			1	1,818.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шилэн дансны цахим хуудаст 5 сая төгрөгөөс дээш гарсан зарим зардлыг мэдээлээгүй.	1						1					
Дүн	1						1					
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Нийт дүн	1						1	-		-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ		1			1			